itools
ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

“АЙТҮҮЛС” ХК-ИЙН 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

www.itools.mn itools.mn 7575 5585

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, хамтран ажиллагсад аа! 2019 оны эхний хагас жил бидний хувьд олон улсын төвшинд хүрэх, үндэс суурь, дэд бүтэц, үйлчилгээний чанараа улам сайжруулахад чиглэсэн хугацаа байлаа. Энэ жил манай компанийн 8 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ төрлийг нэмж, харилцагч хэрэглэгчиддээ бэлэг барьсаар байна.

Айтүүлс компани нь олон улсын жишигт нийцсэн дата төвд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг Монголдоо болон Монголоосоо үзүүлэх зорилгынхоо хүрээнд энэ оны хагас жилд багтан төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартыг (PCI DSS) дата төвийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн Trust Wave компаниар баталгаажуулалт хийлгэлээ. Үйлчилгээ үзүүлэгч компанийн хувьд тус стандартыг хангасан Монголын анхны компани болж олон улсад хүлээн зөвшөөрөгдлөө. Энэ нь манай санхүүгийн дата төвийн үйл ажиллагаа өргөжин тэлэхэд төдийгүй санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг харилцагчдад маань томоохон давуу тал боллоо.

Түүнчлэн дата төвийн ирээдүйн чиг хандлага болсон үүлэн тооцооллын системийг бие даан хөгжүүлж үйлчилгээнийхээ төрлийг нэмэгдүүлсэн юм. "ICS" буюу "Itools Cloud Service" нь бидний өдөр тутам ашиглаж буй Google Drive, Amazon Web Services, Microsoft OneDrive зэрэгтэй ижил горимоор ажиллахаараа онцлогтой.

Тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг амжилттай зохион байгууллаа. Тус хурлаас гарсан шийдвэрийн хүрээнд Айтүүлс ХК нь дархан хотод өөрсдийн эзэмшлийн дэд бүтэц нь бүрэн шийдэгдсэн, одоо ашиглагдаж байгаа барилгатай болсон төдийгүй интернетийн үйлчилгээ үзүүлэгч СНЕТ ХХК-ний хувьцааг 100 хувь эзэмшиж эхэлсэн.
Энэ хагас жилд бид түүхэндээ анх удаа тэрбум давсан борлуулалтыг хийсэн нь эрэлттэй бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж буйн тод илрэл гэж үзэж байна.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг сайжруулах, хялбар хэрэглээг бий болгох зорилгоор цахим хуудас болон хэрэглэгчийн системээ бүрэн шинэчилсэн нь хэрэглэгч, харилцагчийн талархлыг хүлээгээд байна. Бид зогсолтгүй хөгжиж, амжилтаараа ялгарна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ТАМИР

Айтүүлс ХК-ийн хагас жилийн борлуулалтын орлого анх удаа тэрбум давлаа. ББӨ өндөр байгаа нь шинэ төсөл хөтөлбөрүүд эхэлж байгаатай холбоотой ба тун удахгүй өгөөжөө өгч эхлэх, дэлхийн чиг хандлагад бүрэн нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээнүүд байх юм.



Ашгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеийнхээс буурсантай холбоотойгоор хувьцаанд ногдох ашиг (EPS) 1.25 төгрөгт хүрч 0.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэдийгээр EPS бууралттай байгаа ч P/E буюу үнэ ашгийн харьцаа 68.6 болж сайжирсан байна.



Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 1.2 % болж өмнөх оны хагас жилийн үзүүлэлтээс буурсан бол өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 1.4 % болжээ.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН/

Хөрөнгө	Эхний үлдэгдэл (1 сар 1)	Эцсийн үлдэгдэл (6 сар 30)
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	28,763,843.20	61,335,780.16
Дансны авлага	181,146,590.54	151,203,472.91
Татвар, НДШ – ийн авлага		-
Бусад авлага	321,188,924.98	412,956,499.51
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	90,355,536.92	97,057,072.32
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	520,510,397.89	238,585,511.53
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
Эргэлтийн хөрөнгийн дүн	**1,141,965,293.53**	**961,138,336.42**
Үндсэн хөрөнгө	2,256,421,417.02	2,452,528,702.67
Биет бус хөрөнгө	132,249,430.91	132,249,430.91
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт	70,446,145.00	70,446,145.00
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,459,116,992.93	2,655,224,278.58
Эргэлтийн хөрөнгийн дүн	**3,601,082,286.46**	**3,616,362,615.00**
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр	60,175,907.30	110,754,102.29
Дансны өглөг	3,918,681.22	85,271.56
Цалингийн өглөг	121,357,313.20	31,147,137.97
Татварын өр	3,165,291.79	20,750,565.17
НДШ - ийн өглөг		
Богино хугацаат зээл		
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого	245,745,030.17	303,755,524.38
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр	173,168,708.51	112,936,383.25
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН/

Богино хугацаат өр төлбөрийн дүн	**607,530,932.20**	**579,428,984.63**
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Нөөц /өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Өр төлбөрийн нийт дүн	607,530,932.20	579,428,984.63
Эздийн өмч		
Өмч: - төрийн		
- хувийн	905,758,223.28	905,758,223.28
- хувьцаат	1,338,798,000.00	1,338,798,000.00
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	460,721,652.19	460,721,652.19
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	288,273,478.79	331,655,754.90
Эздийн өмчийн дүн	2,993,551,354.26	3,036,933,630.37
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	**3,601,082,286.46**	**3,616,362,615.00**

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН /2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ҮЕИЙН ДҮН	ТАЙЛАНТ ҮЕИЙН ДҮН
Борлуулалтын орлого (Цэвэр)	**1,512,815,765.71**	**1,512,815,765.71**
Борлуулалтын өртөг	597,985,826.33	647,770,783.37
Нийт ашиг (Алдагдал)	**914,829,939.38**	**450,621,761.87**
Түрээсийн орлого	10,909,090.91	5,454,545.45
Хүүний орлого	428,578.78	395,546.76
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	162,250.61	36,283,497.37
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	742,679,505.80	445,039,329.80
Санхүүгийн зардал		
Бусад зардал	7,732,045.00	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	5,945,174.58	2,397,948.69
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	9,331,455.45	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	(1,911,441.31)
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (Алдагдал)	**191,194,938.91**	**48,202,529.02**
Орлогын татварын зардал	19,892,698.39	4,820,252.90
Татварын дараах ашиг (алдагдал)	171,302,240.52	43,382,276.12
Тайлант үеийн цэвэр ашиг (Алдагдал)	**171,302,240.52**	**43,382,276.12**

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМЧ	ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	ХУРАМТЛАГДСАН АШИГ	НИЙТ
2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	2,244,556,223.28	460,721,652.19	288,273,478.79	2,993,551,354.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	2,244,556,223.28	460,721,652.19	288,273,478.79	2,993,551,354.26
Тайлант үеийн цэвэр ашиг (Алдагдал)				
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ногдол ашиг				
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
2017оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,244,556,223.28	460,721,652.19	288,273,478.79	2,993,551,354.26
2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	2,244,556,223.28	460,721,652.19	288,273,478.79	2,993,551,354.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	2,244,556,223.28	460,721,652.19	288,273,478.79	2,993,551,354.26
Тайлант үеийн цэвэр ашиг (Алдагдал)			**43,382,276.12**	**43,382,276.12**
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ногдол ашиг				
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	**2,244,556,223.28**	**460,721,652.19**	**331,655,754.91**	**3,036,933,630.38**

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ҮЕИЙН ДҮН	ТАЙЛАНТ ҮЕИЙН ДҮН
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	**1,372,857,881.66**	**1,543,970,643.19**
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,364,966,032.05	1,202,527,388.08
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	7,891,849.61	341,443,255.11
Мөнгөн зарлагын дүн (-)	**1,423,608,626.87**	**1,447,282,961.08**
Ажиллагчдад төлсөн	207,139,725.30	143,334,769.53
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	55,636,917.06	23,778,557.69
Бараа материал худалдан авахад төлсөн	467,504,826.36	695,718,234.04
Ашиглалтын зардалд төлсөн	108,879,938.60	107,930,695.45
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,999,666.37	4,025,489.86
Хүүний төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	47,794,388.24	306,093,551.30
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	533,653,164.94	166,401,663.20
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(50,750,745.21)**	**96,687,682.11**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	27,871,976.11	77,600,992.20
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	140,000.00	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	27,303,397.33	77,143,519.50
Хүлээн авсан хүүний орлого	428,578.78	457,472.70
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	434,235,527.50	287,296,930.60
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	338,821,811.00	209,152,121.52
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	95,413,716.50	78,144,809.08
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(406,363,551.39)**	**(209,695,938.40)**

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ҮЕИЙН ДҮН	ТАЙЛАНТ ҮЕИЙН ДҮН
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	124,022,327.65	321,196,979.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	124,022,327.65	321,196,979.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	56,098,120.00	178,290,963.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	56,098,120.00	178,290,963.00
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	67,924,207.65	142,906,016.00
Валютын ханшийн зөрүү	5,945,174.58	2,674,177.26
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(383,244,914.37)**	**32,571,936.96**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**412,008,757.57**	**28,763,843.20**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**28,763,843.20**	**61,335,780.16**

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Хувьцааны арилжаа өдөр бүр идэвхитэй явагдаж байгаагаас үзвэл 2018 онд Монголын хөрөнгийн биржийн ТОП 20 индекст багтаж байсан амжилтаа 2019 онд бататгаж чадна гэж дүгнэж байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

02 САР

САНХҮҮГИЙН ДАТА ТӨВИЙН ӨРГӨТГӨЛИЙН АЖИЛ БҮРЭН ДУУСЧ, АШИГЛАЛТАД ОРЛОО.

Аливаа байгууллагын урт хугацаанд тогтвортой, амжилттай ажиллах нэг гол хүчин зүйл нь харилцагчийн дата болон мэдээллийн технологийн шийдэл, дэд бүтэц байдаг. Ялангуяа санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллага бүрт харилцагчийнхаа мэдээллийг Монгол Улсдаа хадгалах хэрэгцээ зайлшгүй тулгардаг. Тус хэрэгцээ шаардлагын хүрээнд манай компани нь Улаанбаатар хот дахь дата төвийн үйл ажиллагаагаа өргөжүүлэн ААНБ-ууд, банк санхүү, брокер диллер, даатгал зэрэг бизнесийн салбаруудын өгөгдлийн найдвартай хадгалахад чиглэсэн орчин үеийн дата төвийн чиг хандлагад тулгуурласан “Санхүүгийн Дата Төв”-ийг бүрэн ашиглалтанд оруулаа.

04 САР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН ЭЭЛЖИТ ХУРАЛ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ ӨНДӨРЛӨЛӨӨ.

“Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 15:00 цагт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу-49 Мэдээллийн технологийн үндэсний паркийн хурлын танхимд боллоо. Тус хурлаар компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн үзүүлэлтүүдийн талаар танилцуулагдаж, нийт 5 асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэлээ.

05 САР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН ХУРЛЫН ШИЙДВЭРЭЭР “СИНЭТ” ХХК НЬ “АЙТҮҮЛС” ХК-ИЙН ОХИН КОМПАНИ БОЛЛОО.

21-р зууныг интернетгүйгээр төсөөлөхийн аргагүй юм. Мөн дата төвийн үйлчилгээний түүхий эд нь интернет байдаг. ХЭХ-ын шийдвэрээр интернетийн үйлчилгээ үзүүлэгч компанийн хувьцаа эзэмшигч болсон нь бидний үйл ажиллагааны явцыг хурдасгах хөшүүрэг боллоо. Бид цаашлаад байгууллагын онцлог, интернетийн хэрэгцээ шаардлагаас хамаарч зөвхөн байгууллагад зориулсан хамгийн найдвартай, өндөр хурдны интернетийн үйлчилгээг санал болгох боломж бүрдлээ.

05 САР

ДАРХАН ХОТОД ДЭД БҮТЭЦ НЬ БҮРЭН ШИЙДЭГДСЭН, АШИГЛАЛТАД ОРСОН 1300 М2 ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН БАЙРТАЙ БОЛЛОО.

Бид өнгөрсөн оны 9 дүгээр сараас эхлэн Дархан хотод байрлах АйСиТи Групп ХХК-ийн байранд “Блокчейн Дата төв”-ийн үйл ажиллагаагаа эхлүүлж байсан билээ. Тус үйлчилгээний гол хэрэглэгчид нь Япон Улсад бүртгэлтэй, үйл ажиллагаа нь олон нийтэд танигдсан групп компаниуд байдаг. Тэгвэл ХЭХ-ын шийдвэрээр дархан хотод байрлах дэд бүтэц нь бүрэн шийдэгдсэн, ашиглалтад бүрэн орсон тус барилга, байгууламж нь Айтүүлс ХК-ийн эзэмшилд шилжлээ. Уг барилгыг эзэмшсэнээр дархан хотод дата төвөө богино хугацаанд нээх боломж бүрдлээ.

06 САР

PCI DSS СТАНДАРТЫН LEVEL1 ТӨВШИНГ ХАНГАЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЛЭЭ.

Энэхүү стандарт нь тухайн байгууллагын хэрэглэгчийн төлбөр тооцооны мэдээлэлд хэрхэн хандах, боловсруулах, хадгалах, дамжуулах үйл ажиллагааг аргачилсан баримт бичгийн бүрдэл юм. Стандартын шаардлагуудыг бүрэн хангасны үндсэн дээр хэрэглэгчийн төлбөр тооцооны мэдээллийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдлага, эрсдэлийг цаг алдалгүй илрүүлэх, яаралтай арга хэмжээ авах, учирсан хохирлыг тооцоолох боломж бүрдэж байгаа юм. Дата төвийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хувьд стандартыг Монголдоо анх удаа хангасанаараа онцлогтой ба тус стандартын баталгаажуулалтыг дэлхийд 3-т ордог “Trust Wave” ОУ-ын компани хийсэн нь өндөр ач холбогдолтой байлаа.

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Монголдоо анхдагч Үндэсний хэмжээний КЛАУД үйлчилгээг нэвтрүүллээ.

Клауд дээр суурилсан вэб байршуулах үйлчилгээ нь олон тооны серверүүд нь нэг том сервертэй адилхан ажиллах боломжийг олгодог харьцангуй шинэ технологи юм.
Клауд үйлчилгээ нь дараах давуу талуудтай байна.

1. Клауд үйлчилгээ нь хэрэглээнээс хамааран төлбөр бодогддог, хэрэглэгчийн хувьд найдвартай үйлчилгээг илүү хямд үнээр ашиглах боломжтой.
2. Дата төвийн үйлчилгээг ашиглахад байгууллагуудад серверийн асуудлууд, дата хадгалалт, өгөгдлийн сан, аппликейшин сервер, интернет гээд маш олон асуудлууд байдаг билээ. Клауд дээр суурилсан вэб байршуулах үйлчилгээг ашигласнаар ямар нэгэн асуудалд санаа зовох зүйлгүй вэб, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетингийн зэрэг бусад асуудлууддаа л үнэт цагаа зарцуулах боломжтой болно. Клауд дээр суурилсан байршуулах үйлчилгээг ашигласнаар таньд тулгардаг технологийн асуудлуудыг бид бүрэн шийдэх болно.
3. Клауд технологи дээр суурилсан таны дата, мэдээллийг онлайн орчинд олон газар зэрэг байршуулснаар мэдээлэл алдагдах эрсдлээс бүрэн хамгаалагдах боломжтой юм.
4. Клауд дээр суурилсан үйлчилгээ нь хэрэглэгч таны бүтээгдэхүүн, үйлчилгээг дэлхийд гаргаад зогсохгүй, цаашид бизнес өргөжин, хэрэглэгчид нэмэгдэж ачаалал ихсэх үед динамик (уян хатан) байдлаар системийн хүчин чадлыг өөрийн хэрэгцээнд тохируулан системээ шууд өргөжүүлээд явах боломжтийг олгодогоороо маш том давуу талтай.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагаа

“Айтүүлс” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 2019 оны II улирлын турш ээлжит болон ээлжит бус байдлаар нийт 3 удаа хуралдлаа. ХЭХ-аар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан, сонгож баталсан шийдвэр гарлаа. ТУЗ нь 2018 оны сүүлийн хагас жилд нийт 8 гишүүнтэй байсан бол ХЭХ-аар компанийн Гүйцэтгэх захирал Баярсайхан овогтой Тамирыг ердийн гишүүнээр сонгон, томилсон. ТУЗ нь 3 хороотой ажиллаж байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрүүдийг Монголын хөрөнгийн биржийн (http://www.mse.mn/mn) цахим хуудаснаас харах боломжтой.